

# ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРАЛ, ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН 2022 ОНЫ 01 ДҮГЭЭР САРЫН ТОВЧ ТАЙЛАН

## НЭГ. УДИРДЛАГА, ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН ТАЛААР

Аймгийн Засаг дарга О.Амгаланбаатар 2022 оны 01 дүгээр сарын 04-ний өдөр Улаанбаатар хотод аймгийн хэмжээнд ашигт малтмалын тусгай зөвшөөрөл эзэмшигч 55 аж ахуй нэгжийн 58 төлөөлөл оролцсон уулзалт, хэлэлцүүлэг зохион байгуулж, "Байгаль орчныг хамгаалах, уурхай ашиглах, үйлдвэр байгуулахтай холбогдсон дэд бүтцийг хөгжүүлэх, ажлын байр нэмэгдүүлэх" чиглэлээр өмнө байгуулсан гэрээг энэ оны 01 дүгээр улиралд багтаан дүгнүүлэх, цаашид орон нутагтай харилцан ашигтай хамтран ажиллах, хариуцлагатай уул уурхайг хөгжүүлэх чиглэлээр санал солилцлоо.

Аймгийн "Аварга малчин, тариаланч, саальчин" шалгаруулах журмын дагуу аймгийн "Аварга малчин"-110, "Аварга тэмээчин"-1, "Аварга саальчин"-7, "Аварга тариаланч"-4, "Аварга хадланч"-2 тус тус шалгаруулан Алтай хотод шагналыг гардуулах ёслолыг зохион байгуулж, хүндэтгэл үзүүллээ.

2021 онд төрийн үйлчилгээг иргэд олон нийтэд чирэгдэлгүй түргэн шуурхай хүргэж, Коронавируст халдвар /КОВИД-19/-ийн цар тахлын эрсдэлээс урьдчилан сэргийлэх үйл ажиллагааг удирдлага арга зүйгээр ханган үр дүнтэй зохион байгуулан ажилласан аймгийн "Тэргүүний хамт олон" болон салбарын чиглэлээр аймгийн "Хөдөлмөрийн аварга"-ыг шалгаруулан шагналыг гардууллаа.

Мэдлэг, авьяас, хичээл зүтгэлээрээ тэргүүлэн сурлага, спорт, урлаг болон бусад төрлөөр амжилт гарган бусдыгаа манлайлан суралцаж байгаа 2021 оны "Онцлох хүүхэд"-ийг алдаршуулан 01 дүгээр сарын 28-ны өдөр аймгийн Засаг дарга О.Амгаланбаатар шагналыг гардууллаа.

**Төрийн үйлчилгээний чиглэлээр:** Үйлчилгээний нэгдсэн төвд 6 байгууллагын 12 албан хаагч 01 дүгээр сарын байдлаар давхардсан тоогоор 1927 иргэн, хуулийн этгээдэд төрийн үйлчилгээг нэг цэгээс хүргэн ажиллалаа.

**Өргөдөл гомдлын талаар:** Тайлант хугацаанд аймгийн Засаг даргад хандан 8, аймгийн Засаг даргын Тамгын газрын Даргад 6, аймгийн Засаг даргын орлогчид 1, аймгийн Засаг даргын Тамгын газрын Санхүү төрийн сангийн хэлтэст 1, Төрийн албаны салбар зөвлөлд 1, нийт 17 өргөдөл бичгээр ирснээс 14 өргөдлийг шийдвэрлэж, 3 өргөдөл хяналтын хугацаандаа судлагдаж байна. Шийдвэрлэлт 82,35% байна.

"Иргэдээ сонсох нээлттэй утас 7048-1111" дугаарын утсанд 01 дүгээр сарын байдлаар нийт 57 дуудлага хүлээн авснаас, хувийн мэдээллээ бүрэн өгсөн 49 гомдол, санал, хүсэлтийг E-office программд бүртгэн, холбогдох байгууллага, албан тушаалтанд шилжүүлэн, шийдвэрлэлтэд хяналт тавин ажиллаж байна.

**Цахим үйлчилгээний талаар:** E-Mongolia төрийн үйлчилгээний нэгдсэн цахим операторын системээр нийт 13 байгууллагын 64 нэр төрлийн лавлагаа, мэдээллийг иргэдэд нэг шатлалаар, биеийн давхардашгүй өгөгдөл болох хурууны хээгээр олгож байна.

Тайлант хугацаанд операторын системээр иргэдэд олгох боломжтой 64 төрлийн төрийн цахим мэдээллийн үйлчилгээг 52 иргэнд төлбөртэй, 120 иргэнд төлбөргүй, нийт 172 лавлагаа мэдээлэл гаргаж үйлчиллээ.

Нийт [WWW.OPERATOR.E-MONGOLIA.MN](http://WWW.OPERATOR.E-MONGOLIA.MN) цахим мэдээллийн системээр үзүүлсэн лавлагаа, тодорхойлолтын үйлчилгээний хураамж болох 65000 төгрөгийг холбогдох дансанд цахим төлбөрийн Q-руу үйлчилгээ ашиглан төвлөрүүллээ.

Төрийн цахим үйлчилгээний E-mongolia сайтыг танилцуулах, шаардлагатай лавлагаа тодорхойлолтуудыг нэг шатлалаар богино хугацаанд авах, цахим порталын хэрэглээг нэмэгдүүлэх үүднээс үйлчилгээний нэгдсэн төвөөс иргэдэд мэдээ мэдээлэл, заавар зөвлөмжийг байнга хүргэн ажиллаж байна. Иргэдийн хүсэлтээр ДАН танилт нэвтрэлтийн систем ашиглан, хувийн мэдээллээр нь бүртгэл үүсгэж, хэрэгцээтэй лавлагаа тодорхойлолтуудыг 192 иргэнд үнэ төлбөргүй гарган үйлчиллээ.

Сумдын цахим мэдээлэл лавлагааны дүнг нэгтгэж, тайлан мэдээг Харилцаа холбооны зохицуулах хороонд сар бүрийн 05-ны дотор хүргүүлэн ажиллаж байна.

## **ХОЁР. ХУУЛЬ, ЭРХ ЗҮЙН БОДЛОГЫН ХҮРЭЭНД**

Аймгийн хэмжээнд Хувийн ашиг сонирхлын болон хөрөнгө, орлогын мэдүүлэг бүрдүүлэлтийн ажил явагдаж, 144 мэдүүлэг гаргагч [meduuleg.iaac.mn](http://meduuleg.iaac.mn)-нд цахимаар мэдүүлж, цаасаар бүртгүүллээ.

Нийтийн албанд томилогдохоор нэр дэвшиж буй 8 хүний хувийн ашиг сонирхлын урьдчилсан мэдүүлгийг [meduuleg.iaac.mn](http://meduuleg.iaac.mn)-д цахим системд бүртгэж, томилох эрх бүхий албан тушаалтны албан бичгээр Авлигатай тэмцэх газрын хяналт шалгалт дүн шинжилгээний хэлтэст хүргүүллээ.

Эрх зүйн хөтөч нарын 2021 онд хийсэн ажлын тайланг Хууль зүйн үндэсний хүрээлэнгийн бүх нийтийн эрх зүйн боловсролын зөвлөлд хүргүүлэн ажиллалаа.

Халиун, Төгрөг, Цээл, Цогт, Эрдэнэ сумдын малын тоо толгойн албан татвар тогтоосон шийдвэрийн бүрдлийг хангуулж, Хууль зүй, дотоод хэргийн яамд хянуулахаар хүргүүллээ.

**Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газар:** 2022 оны 01 дүгээр сард хүүхдийн тэтгэлэгийн нийт 110 гүйцэтгэх баримт бичигт ажиллагаа явуулж, хаяг тодорхойгүй тэтгэлэг төлөгч нарыг цагдаагийн байгууллагын ASAP санд бүртгүүлэн хамтран ажилласнаар 5 тэтгэлэг төлөгчийн хаягийг тогтоон харьяаллын дагуу шилжүүлэн 4 тэтгэлэг төлөгчийг олж тогтоон хуримтлагдсан тэтгэлгийг төлүүлсэн үлдэгдэл гүйцэтгэх баримт бичгүүдэд шийдвэр гүйцэтгэх ажиллагааг жигд зохион байгуулан ажиллаж байна.

Газрын хэмжээнд шийдвэр гүйцэтгэх ажиллагаанд 8 хоригдолд холбогдох 39 гүйцэтгэх баримт бичгийн 88316,0 мянган төгрөгийн хохирол шийдвэр гүйцэтгэлийн ажиллагаа явуулж, нийт 7 гүйцэтгэх баримт бичгийн 16106,3 мянган төгрөгийг бүрэн дуусгавар болгож цахим бүртгэлд төлөлтийг бүртгэн, хорих ял эдэлж буй ангиудын холбогдох алба хаагчдад төлбөр төлөлтийн мэдээллийг тухай бүр хүргүүлэн 5 хоригдолын 32 гүйцэтгэх баримт бичгийн 54996,8 мянган төгрөгийн үлдэгдэлтэй ажиллаж байна.

**Шүүхийн шинжилгээний алба:** Тайлант сард эрүүгийн хэрэгт мөрдөгч, прокурорын тогтоолийг үндэслэн 1, эрх бүхий бусад байгууллага албан тушаалтны

хүсэлтээр 2 криминалистикийн шинжилгээ хийсэн. Хэргийн газрын үзлэгт 52 удаа оролцсоноос хүний амь нас хохирсон 7, хулгайлах 6, зам тээврийн ослын 10, бусад 29 хэрэгт үзлэг шинжилгээ хийсэн байна. Мөн шинжилгээний 38 ширхэг, хэргийн газрын үзлэгийн 506 ширхэг, цогцосны үзлэг, задлан шинжилгээний 154 ширхэг, бусад 572 нийт 1270 ширхэг гэрэл зураг авсан. Гарын хээний дардас 83 ширхэгийг хийж гарын мөрний санг баяжуулсан.

**Улсын бүртгэлийн хэлтэс:** Тайлант хугацаанд 114 лавлагаа олгож, гадаад паспорт захиалга 5, шинээр 6, дахин 2 нийт 8 хуулийн этгээдийг бүртгэн гэрчилгээ олгосон.

Иргэд хуулийн этгээдийн Эд хөрөнгө өмчлөх эрх болон түүнтэй холбоотой бусад эрхийн 120 мэдүүлэг хүлээн авч шийдвэрлэн, бүртгэлийн үйлчилгээний хураамж 1,258,516 төгрөг, улсын тэмдэгтийн хураамж 22,500 төгрөг, татварын орлогод 4,100,000 төгрөгийг тус тус улсын болон орон нутгийн төсөвт төвлөрүүлээ.

Тус хугацаанд улсын бүртгэлд тогтоосон хугацаанд бүртгүүлээгүй журам зөрчсөн үйлдэлд хялбаршуулсан журмаар зөрчил шалган шийдвэрлэх ажиллагаа явуулж 15 иргэнд 300,000 төгрөгийн торгууль ноогдуулсан. Мөн иргэний бүртгэлийн чиглэлээр 3, хуулийн этгээд 2, нийт 5 дүгнэлтээр 5 бүртгэлийн зөрчлийг арилгаж шийдвэрлэсэн.

**Цагдаагийн газар:** 2022 оны 01 дүгээр сард гэмт хэрэг, зөрчлийн шинжтэй 186 гомдол, өргөдөл мэдээлэл хүлээн авч шалгаснаас гэмт хэргийн шинжтэй 65, зөрчлийн шинжтэй 121 гомдол, мэдээлэл байна. Гэмт хэрэг, зөрчлийн шинжтэй 65 гомдол, өргөдөл, мэдээллийг өмнөх оны мөн үетэй харьцуулахад 18 нэгжээр буюу 38,3 хувиар өссөн байна. Гэмт хэргийн болон зөрчлийн шинжтэй гомдол, мэдээллийн 110 буюу 59,1 хувийг хуулийн анхны хугацаанд шийдвэрлэсэн байна.

Мөн аймгийн хэмжээнд төрийн болон аж ахуйн нэгж, байгууллага, иргэдийн өмч хөрөнгөнд 177,3 сая төгрөгийн хохирол учирсан 49 гэмт хэрэг үйлдэгдсэнийг өнгөрсөн оны мөн үетэй харьцуулбал хэрэг 27 хэргээр буюу 2,2 дахин, учирсан хохирол 160 сая төгрөгөөр буюу 10,3 дахин тус тус өссөн үзүүлэлттэй байна.

231 гэмт хэрэгт нийт 212 хүн холбогдож, гэмт хэргийн улмаас 8 хүн нас барж, 94 хүн гэмтсэн байна.

Хөнгөн гэмт хэрэг 29 бүртгэгдсэн нь 11 нэгжээр буюу 61 хувиар, хэрэг бүртгэлтийн хэрэг 43 бүртгэгдэж 25 нэгжээр буюу 2,3 дахин, мөрдөн байцаалтын хэрэг 6 бүртгэгдэж 2 нэгжээр буюу 50 хувиар, хүнд гэмт хэрэг 20 бүртгэгдсэн нь 16 хэргээр буюу 5 дахин тус тус өссөн байна.

## **ГУРАВ. ЭДИЙН ЗАСАГ, ТӨСӨВ, САНХҮҮ, ХУДАЛДАН АВАХ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЧИГЛЭЛЭЭР**

**Аймгийн төсөв санхүүгийн чиглэлээр:** 01 дүгээр сарын төсвийн гүйцэтгэлээр орон нутгийн төсөвт 669,2 сая төгрөг төвлөрүүлэхээс 664,2 сая төгрөг төвлөрүүлж төлөвлөгөөг 99,3 хувиар биелүүллээ.

Аж ахуйн нэгж байгууллагын 2021 оны жилийн эцсийн санхүүгийн тайланг Е-баланс цахим системээр хүлээн авч, тайлангийн ирц 13 хувьтай, шинээр нээгдсэн улсын болон орон нутгийн төсвийн дансуудыг Фрийбаланс, Цалингийн нэгдсэн систем, Эрхийн бүртгэлийн санд тохируулан баталгаажууллаа.

**Худалдан авах ажиллагаа:** 01 дүгээр сард ОНХС-ийн хөрөнгөөс санхүүжих 12, улсын төсвөөс санхүүжих 7, орон нутгийн төсвөөс санхүүжих 8 нийт 27 ажлын гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах тендерийг зарлалаа.

**Өмчийн харилцааны талаар:** Аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн Тэргүүлэгчдийн хурлын 2021 оны 98 дугаар тогтоолын дагуу нээлттэй дуудлага худалдааг зарлаж “Өнөөдөр сонин”-д зарыг байршууллаа.

## **ДӨРӨВ. ХӨДӨӨ АЖ АХУЙН ЧИГЛЭЛЭЭР**

**Хөдөө аж ахуйн салбарт:** 01 дүгээр сарын 10,11-ний өдрүүдэд Есөнбулаг сумын 25 иргэнд “Сүү цагаан идээ боловсруулах” сургалтыг зохион байгууллаа.

2021 оны жилийн эцсийн байдлаар 88 багийн 7915 малчин өрхөд нийт 2988.8 мянган толгой мал, үүнээс адуу-115.4, тэмээ-43.7, үхэр-69.5, хонь-885.5, ямаа 1874.7 толгой тус тус тоологдсон байна. Урьд оны малаас адуу 6.7, тэмээ 200, үхэр 6.4, хонь 60.4, ямаа 248,5 толгойгоор буурч нийт 9,7 хувиар малын тоо цөөрсөн байна.

Улсын аварга малчинд 11 сумын 18, Улсын хошой аварга малчинд 3 сумын 3 малчин материалаа ирүүлснээс ХХААХҮЯ-нд 14 малчны материалыг хүргүүлснээс “Улсын аварга малчин”-аар Жаргалан сумын Бүрэн багийн Чулуунбаатарын Лагваа, Тайшир сумын Далан багийн Дэлгэрийн Батболд, Тонхил сумын Алтансоёмбо багийн Бат-Очирын Мянганбаяр, Төгрөг сумын Тунгалаг багийн Тардадын Чулуунбаатар, Цээл сумын Жаргалт багийн малчин Чулуунбатын Гансүх, “Монгол Улсын Хошой аварга малчин”-аар Халиун сумын малчин Банзрагчийн Мулч, Улсын аварга тариаланчаар Бигэр сумын Ивановын Болдбаатар тус тус шалгарлаа.

“Газар тариалан, жимс жимсгэнэ” төсөл арга хэмжээ болон “108 сая мод тарьж, ургуулах аян”-ыг хэрэгжүүлэх ажлын хүрээнд 2022 онд орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр нийт 9 багц ажлын даалгаврыг боловсруулан батлуулж, худалдан авах ажиллагааг зохион байгуулж байна.

**Мал эмнэлгийн чиглэлээр:** Аймгийн хэмжээнд нийтдээ 10 сум, 26 баг, 28 голомт, 203 өрхөд шүлхийн халдвар бүртгэгдэж, голомтод 1058-үхэр, 3250-хонь, 4292-ямаа, нийт 8600 мал өвчилсөн. 1058-үхэр, 3218-хонь, 4101-ямаа, нийт-8377 малын буюу 97.4%-д шинж тэмдэг арилсан байна. Шинж тэмдэгтэй 219 мал байна. Голомтын болон сэжигтэй бүсийн 416299 м<sup>2</sup> талбайд халдваргүйтгэл хийгдэж 203 кг бодис зарцууллаа. Постоор дамжин өнгөрсөн нийт 1678 тээврийн хэрэгслийн 33560 м<sup>2</sup> талбайд халдваргүйтгэл хийгдэж 16.7 кг бодис зарцууллаа. Вакцинжуулалтад 1648 малчин өрхийн 516552 толгой малыг хамруулаад байна.

**Жижиг дунд үйлдвэрлэлийн чиглэлээр:** Аймгийн Жижиг дунд үйлдвэрлэлийг хөгжүүлэх сангийн зээлийн эргэн төлөлтөөс 11 иргэн, ААН-д 330,0 сая төгрөгийн зээл олгохоор аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн 11 дүгээр сарын 30-ны өдрийн 90 дүгээр тогтоолоор шийдвэрлэж, Жижиг дунд үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэгчдээ дэмжиж ажиллалаа.

## ТАВ. ГАЗРЫН ХАРИЛЦАА, БАРИЛГА ХОТ БАЙГУУЛАЛТЫН ЧИГЛЭЛЭЭР

**Газрын харилцааны чиглэлээр:** Газрын эзэмших эрхийн гэрчилгээг бусдад барьцаалах цахим /[www.egazar.gov.mn](http://www.egazar.gov.mn)/-аар 35 өргөдөл ирснийг бүрэн шийдвэрлэж барьцаалах тэмдэглэгээг хийж ажиллалаа.

Есөнбулаг сумын ОНХС-ийн 51.0 сая төгрөгийн санхүүжилтээр 286 гудамж, нийтийн эзэмшлийн өргөн чөлөө буюу 70 гудамж, 680 орон сууц, 3578 гэр хорооллын хашаа, нийт 4788 ширхэг хаягжуулалтын тэмдэг тэмдэглэгээг суурилуулах ажлыг “Чингисийн дуулга констракшн” ХХК-аар гүйцэтгэж, чанар стандартад нь хяналт хийж дуусган хүлээж авлаа.

Газар зүйн нэрийн мэдээллийн дэд систем нь <https://nsdi.gov.mn/> сайтад орж УИХ-н 2003 оны 10 дугаар сарын 31-ний өдрийн А/42 дугаар тогтоолоор Цээл сумын нутаг дэвсгэрт орж батлагдсан нэрсийг мэдээллийн санд тулгалт хийж гүйцэтгэн ажиллаж байна. Цээл сумын хэмжээнд нийт 1030 нэр батлагдсан байна.

Аймгийн Засаг даргын газар эзэмших захирамжаар 15 иргэн, аж ахуй нэгж байгууллагуудад орон сууц, үйлчилгээний зориулалтаар тус тус газар эзэмших эрхийн гэрчилгээ олгож, гэрээ байгуулсан.

Газар эзэмших эрхийн гэрчилгээний лавлагааг 31 иргэнд [www.egazar.gov.mn](http://www.egazar.gov.mn) сайтаас гаргаж үйлчилсэн.

**Нийтийн аж ахуйн талаар:** “Ундарга-Алтай” ААТҮГ-т цэвэр, бохир устай холбоотой нийт 97 санал, гомдол ирснийг 100 хувь шийдвэрлэж ажиллалаа. 01 дүгээр сард Алтай хотын иргэдэд нийт 47552м<sup>3</sup> усыг түгээсэн байна.

**Агаарын тээвэр:** 01 дүгээр сард нийт 6 нислэг хүлээн авч, Алтай-Улаанбаатар чиглэлд 125 зорчигч, 1008 кг тээш, Улаанбаатар-Алтай чиглэлд 149 зорчигч, 1258 кг тээш тээвэрлэсэн байна.

**Техникийн хяналтын үзлэг:** 01 дүгээр сарын 03-ны өдрөөс 31-ны өдрийг хүртэл техникийн хяналтын үзлэгт нийт 459 тээврийн хэрэгсэл хамрагдлаа.

**Хот хоорондын зорчигч тээвэрлэлт:** Тайлант сард нийт 2550 орчим иргэдэд хот хоорондын зорчигч тээвэрлэлтийн талаарх мэдээлэл хүргэж, зорчих тасалбар олгож үйлчиллээ. Мөн 54 тээврийн хэрэгслээр хот хоорондын зорчигч тээвэрлэлтийн үйлчилгээ үзүүллээ.

**Мэдээлэл харилцаа холбооны чиглэлээр:** Онгоц толгой сайтын 1, 3 селлийн RRU-г сольж битүүмжлэл хийн ажиллаж байна.

Дэлгэр, Гуулин, ПРС-121-р станцад антенн суурилууллаа.

## ЗУРГАА. НИЙГМИЙН САЛБАР

**Боловсролын чиглэлээр:** 01 сарын 04-07-ны хооронд "Хичээл сургалтын үр дүнг үнэлэх шалгуурыг хэрэглэх арга зүй, аргачлалыг таниулах" цахим сургалт зохион байгуулагдаж 266 багш хамрагдлаа.

Есөнбулаг сумын "Зөвлөх багш" мэргэжлийн зэрэгтэй багш нарын уулзалт хэлэлцүүлэг зохион байгуулж Боловсрол, шинжлэх ухааны газрын дэргэдэх “Зөвлөх багш зөвлөж байна” нэртэй клуб байгуулж жилийн ажлын төлөвлөгөө боловсрууллаа.

Боловсрол, шинжлэх ухааны газраас анхан жилдээ ажиллаж байгаа сургууль, цэцэрлэгийн багш нарт зориулсан чиглүүлэх, арга зүйн дэмжлэг үзүүлэх 2 өдрийн сургалтыг 01 дүгээр сарын 12, 13-ны өдрүүдэд зохион байгууллаа.

НҮБ-ын Хүүхдийн сангийн санхүүжилтээр хэрэгжиж буй "Банхар арт терапи" төслийн хүрээнд Говь-Алтай аймгийн нийт 31 цэцэрлэг, 28 ерөнхий боловсролын сургуулийн 1100 гаруй багш, албан хаагчдад зориулсан "Ажлын байранд стресс бууруулах", "Үе тэнгийнхний дээрэлхэлтэнд өртсөн хүүхдүүдийг хэрхэн таньж мэдэх", "Хүүхэд хүмүүжлийн эерэг аргыг хэрэглэх нь", "Хүүхэдтэй ажиллах Япон улсын сайн туршлага" сэдэвт цахим сургалтыг амжилттай зохион байгууллаа.

Монгол үндэсний бичиг, бичгийн өв соёлыг түгээн дэлгэрүүлэх цаашид түүчээлэн уухайлах зорилгоор "Бийрийн анир" уран бичлэгийн сургалтыг 01 дүгээр сарын 10-14-ний хооронд амжилттай зохион байгууллаа.



**Эрүүл мэндийн чиглэлээр:** Коронавируст халдварын тандалтаар 2021 оны 01 дүгээр сарын 01-30-ны өдрийн хугацаанд коронавирус халдварт өвчнөөр батлагдсан хүний ойрын хавьтлын 5775 иргэнийг шинжилгээнд хамрууллаа.

Аймгийн хэмжээнд нийт батлагдсан тохиолдолын тоо 15546 үүнээс 01 дүгээр сард батлагдсан 2462 хүн эерэг гарч 7386 хүнийг гэрийн ажиглалтанд авлаа.

Дархлаажуулалтад хамрагдвал зохих 43485 хүнээс Вакцины 1-р тунд 39271 хүн буюу 90.4 хувь, 2-р тунд 37641 буюу 86.5 хувь 3-р тунд 16242 буюу 43.2 хувь нь хамрагдаад байна. Вакцины нөөц 6370 хүн.тун байна.

Hinfo.mn сайтад халдварын батлагдсан 2464 тохиолдлыг бүртгэлжүүлсэн байна.

Эрүүл мэндийн сайдын 01 дүгээр албан даалгаврыг хэрэгжүүлэн Нэгдсэн эмнэлэгт Коронавируст халдвар батлагдсан иргэдийг үзэж эрэмбэлэх амбулаторийг нээн ажиллуулж эхэллээ. Тус амбулаториар 215 иргэнийг үзэж 32 иргэнийг эмнэлэгт хэвтүүлж, хэвтэх шаардлагагүй иргэдэд зөвлөгөө өгч, өрхийн эрүүл мэндийн төвийн хяналтад шилжүүллээ.

Аймгийн Нэгдсэн эмнэлэгт 01 дүгээр сард 3829 ор хоногийг ашигласнаас хүнд өвчтөн 57 байсан ба нас баралтын 1 тохиолдол бүртгэгдлээ. Амбулаториар нийт 6931 үйлчлүүлэгч үзүүлснээс томуу томуу төст өвчтэй 182 тохиолдол бүртгэгдлээ.

01 дүгээр сард нийт 58 эх эсэн мэнд амаржиж 58 хүүхдийг хүлээн авлаа. Мөн 73 мэс засал хийснээс мэс заслын тасагт 45, гэмтлийн тасагт 10, төрөх, эмэгтэйчүүдийн тасагт 18 өвчтөн байна. Түргэн тусламжийн 314 дуудлагад үйлчиллээ. Яаралтай тусламжийн тасагт 295 хүн өөрөө ирж үзүүлснээс томуу,

томуу төст өвчний тохиолдол 18 бүртгэгдлээ. Алсын дуудлагын 7 тохиолдолд хүрч үйлчиллээ.

Тархвар судлалын 03 дугаар долоо хоног буюу 01 дүгээр сарын 24–ний өдрийн байдлаар аймгийн хэмжээнд амбулаториар 2264 үзлэг хийснээс 57 буюу 2.5% нь, яаралтай тусламжийн 133 дуудлага хүлээн авч үйлчилснээс 24 буюу 18% нь томуу томуу төст өвчин бүртгэгдлээ. Нэгдсэн эмнэлгийн 28 ортой хүүхдийн тасагт 8 хүүхэд хэвтэн эмчлүүлж байгаагаас 4 буюу 50% нь томуу, томуу төст өвчний шалтгаантай хэвтэн эмчлүүлж байна.

**Соёлын чиглэлээр:** Аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрт тусгагдсаны дагуу Ардын дуу бүжгийн Алтай чуулга, “Хан хуур” төгөлдөр хуурын сургалтын төвтэй хамтран баруун бүсийн өсвөрийн төгөлдөр хуурчдын “Зулай цагаан Алтай” уралдаант наадам зохион байгуулж, Говь-Алтай, Ховд, Увс, Баян-Өлгий аймгуудын 28 өсвөрийн төгөлдөр хуурчид 4 насны ангилалд ур чадвараа сорьж, шилдгүүдээ шалгарууллаа.

Соёлын яамны санхүүжилтээр явагдах улс, аймгийн хамгаалалттай түүх, соёлын үл хөдлөх дурсгалын 2021 оны улсын тооллогын ажлыг Соёл, урлагийн газар болон Орон нутгийн судлах музейн хамтарсан ажлын хэсэг Хөхморьт, Баян-Уул, Жаргалан сумдаар ажиллаж байна.

“Угийн бичгээ хөтөлж удмын сангаа хамгаалъя” шилдэг угийн бичиг хөтөлсөн сум, баг өрх шалгаруулахаар удирдамж боловсруулан ажиллаж байна.

**Нийтийн номын сан:** 01 дүгээр сард 61 шинэ уншигч бүртгэн 410 ирцэд 599 ном олгож үйлчлэв. Уншигчдад аман болон бичгийн 4 лавлагаа, 2 татгалзал бүртгэн үйлчиллээ. Гэрээр ном олгох тасаг, Уншлага үйлчилгээний 2 танхимаас нийт 45 ширхэг ном сэргээн засварлаж уншигчдад үйлчиллээ.

**Гэр бүл, хүүхэд, залуучуудын байгууллага:** НҮБ-ын Хүүхдийн сангийн дэмжлэгтэйгээр аймгийн Улаан Загалмай Хороотой хамтран Коронавирус халдвараар өвдсөн бага насны хүүхдүүд болон тэдний асран хамгаалагчдад “НИЙГЭМ СЭТГЭЛ ЗҮЙН ДЭМЖЛЭГ ҮЗҮҮЛЭХ” сургалтыг 01 дүгээр сарын 12-ны өдөр зохион байгуулж, 50 хүүхдийг хамрууллаа.

Аймгийн Шүүхийн Тамгын газрын шүүгч, албан хаагчдад сэтгэл зүйн боловсрол олгох зорилготой “Өөрийгөө хайрлахуй” сургалтыг 01 дүгээр сарын 14-ний өдөр зохион байгуулж нийт 15 албан хаагчдыг хамрууллаа.

Зөрчлийн улмаас баривчлах шийтгэл хүлээсэн иргэдэд зөв дадал хэвшлийг бий болгох зорилготой “Зан үйлд нөлөөлөх албадан сургалт”-ыг аймгийн Цагдаагийн газартай хамтран 01 дүгээр сарын 11-ний өдөр зохион байгуулж, 14 хүнийг хамрууллаа.

Нийгмийн ажилтны нэгдсэн систем /НАМС/-ийг ашиглаж эхлэхтэй холбогдуулан аймгийн хэмжээнд ажиллаж буй 30 хамтарсан багийн ахлагч, нарийн бичиг нийт 60 хүний мэдээллийг цуглуулж, системд нэвтрэх эрхийг үүсгэж ажиллалаа.

“Гэр бүлд зөвлөгөө өгөх төв”-өөр насанд хүрэгч-12, хүүхэд-4, нийт 16 хүнд сэтгэл зүйн зөвлөгөө үйлчилгээг үзүүлж ажиллалаа.

Эрүүл мэндийн газар, Дэлхийн зөн ОНХХ-тэй хамтран “Хүүхэд хамгаалал-Бидний оролцоо” сургалтыг 01 дүгээр сарын 12-ны өдөр Хүүхэд залуучуудын ордны хурлын танхимд 40 эцэг эхийг хамруулан зохион байгууллаа.

Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газрын даргын А/121 дүгээр тоот тушаалаар бүтэн өнчин хүүхдийн нөхцөл байдлыг тодруулан, үнэлгээ хийж, шаардлагатай үйлчилгээг үзүүлэх, хүүхэд хамгааллын чанар хүртээмжийг нэмэгдүүлэх, тогтвортой байдлыг хангах ажлыг Хамтарсан багийн нарийн бичиг нартай хамтран зохион байгуулж, 54 бүтэн өнчин хүүхдийн орчин нөхцлийг үнэлэхэд 1 хүүхэд нас барж /хөгжлийн бэрхшээлтэй/, 1 хүүхэд үрчлэгдэж, 1 хүүхэд улаан бүсэд холбоо барих боломжгүй байсан тул 51 хүүхдийн мэдээллийг COBO COLLECT программын асуулгын дагуу бөглөж судалгааны багийнханд илгээлээ.

**Хөдөлмөр, халамжийн чиглэлээр:** 01 дүгээр сарын 25-ны байдлаар аймгийн хэмжээнд нийт 988 иргэн идэвхтэй ажил хайгчаар бүртгэлтэй байгаа ба 458 нь эмэгтэй байна.

Тайлант сард бүртгэлтэй ажил хайгч иргэдийг боловсролын түвшингээр нь авч үзвэл 515 буюу 52,1% нь бүрэн дунд, 279 буюу 28,2% нь дээд, 112 буюу 11,3% нь тусгай мэргэжлийн болон техникийн мэргэжлийн боловсролтой байна. Мөн бүртгэлтэй ажилгүй иргэдийг насны байдлаар нь авч үзвэл 35,6% нь 25-34 насны залуучууд, 15-24 насны залуучууд 15.1%-ийг, 35-44 насны иргэд 25,7% -ийг эзэлж байна.

Тайлант сард аймгийн хэмжээнд 14 иргэн ажлаасаа чөлөөлөгдөж, ажилгүйдлийн тэтгэмжийн тодорхойлолт авсан байна.

## **ДОЛОО. БАЙГАЛЬ ОРЧИН, АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ЧИГЛЭЛЭЭР**

Говийн зэрлэг, нэн ховор амьтан болох Хавтгай тэмээний амьдардаг экосистемийг хамгаалах өсгөн үржүүлэх зорилгоор Говийн Их дархан Цаазат газрын А хэсгийн Улсын Тусгай хамгаалалттай газрын Орчны бүсийн сумд, Хил хамгаалах байгууллага бусад талууд оролцсон “Орчны бүсийн хамтын менежментийн зөвлөлийн II дугаар” уулзалтыг Лондонгийн Амьтан Судлалын Нийгэмлэгийн Монгол дахь Төлөөлөгчийн газартай хамтран 01 дүгээр сарын 07-09-ний өдрүүдэд Цогт сумын Баянтоорой тосгонд зохион байгуулж ажиллалаа.

## **ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР**